



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/11

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 1 дүгээр баг, 12 дугаар байрны баруун талд байршилтай, иргэн Адъяа овогтой Ундралын “Автогараж”-ийн зориулалттай 21 м2 газрыг “Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ”-ний дагуу иргэн Боржигин овогт Дашзэвэгийн Баярхүүд “Автогараж”-ийн зориулалтаар, тус 21 м2 газрыг 9 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмшигч иргэн (Дашзэвэгийн Баярхүү)-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч иргэн Дашзэвэгийн Баярхүүтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Э.Баярмагнай)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны А/181 дугаар захирамжийн 9 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ